



## НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

### Буудлагын тэмцээн зохион байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2, 13.3.5, 30 дугаар зүйлийн 30.2, 30.3, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2015 оны 932 дугаар тушаалаар батлагдсан “Буудлага хийх үеийн аюулгүй арга хэмжээний заавар”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой байдлын газрын Марш тусгай бэлтгэлийн дадлага сургуулийн хүрээнд офицер бүрэлдэхүүний дунд буудлагын тэмцээнийг Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр Хүй долоон худаг “Монгол наадам” цогцолборын тусгайлан бэлтгэсэн буудлагын талбайд зохион байгуулсугай.

2. Тэмцээний удирдамжийг нэгдүгээр, буудлага үйлдэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Буудлагын тэмцээний үед галт зэвсгийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг чанд мөрдөж ажиллахыг нийслэлийн Аврах анги-105 (хошууч Ш.Мэндсайхан)-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т үүрэг болгосугай.

ДАРГА,  
ХУРАНДАА



Ж.ЦУЛТЭМСҮРЭН

Нийслэлийн Онцгой байдлын Газрын даргын  
2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн  
А/ИТ дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

БУУДЛАГЫН ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ТУХАЙ УДИРДАМЖ

УХА0038 9077073

Зорилго: Офицер бүрэлдэхүүний авхаалж самбаа цэц мэргэнийг сорьж, цэргийн албаны бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

Тэмцээн явуулах хугацаа, байршил:

2018 оны 03 дугаар сарын 02-ны өдөр 11 цагт Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр Хүй долоон худаг "Монгол наадам" цогцолбор

Буудлагын тэмцээний төрөл:

Тусгайлан бэлтгэсэн талбайд 25 метрийн зайд 9 мм-ийн ПМ гар буугаар 3 сум буудаж онооны нийлбэр дүнгээр байр эзлүүлнэ. Тамирчид 2 сумаар туршилтын буудлагыг үйлдэнэ.

Зохион байгуулалт:

Тэмцээнд оролцох алба хаагчид буудлага үйлдэх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцаж гарын үсэг зурсан байна.

Тэмцээнд оролцох алба хаагчид нь шүүгч, дасгалжуулагч нарын өгсөн зааварчилгаа, дэг журам, зохион байгуулалтыг чанд сахиж оролцоно.

Тэмцээн эхлэхээс 30 минутын өмнө оролцох алба хаагчид бүртгүүлнэ.

---oOo---

Буудлага хийх үед авах аюулгүйн  
ажиллагааны зааварчилгаа



Буудлага хийх үед дараах аюулгүйн ажиллагааны зааварчилгааг авч хэрэгжүүлнэ.  
Үүнд:

- Буудлагын удирдагч нь аюулгүйн арга хэмжээг ягштал дагаж мөрдөхийг буудлагад оролцогч бүх бие бүрэлдэхүүнээс шаардаж, түүний биелэлтэд байнга хяналт тавина.

- Буудлагын удирдагчийн команд дохиогоор бүх үйл ажиллагааг явуулна. Зөвхөн галын шугаман дээр буудлагын удирдагчийн команд дохиогоор бууг цэнэглэнэ. "БАЙЛДААНД" командаар сумтай магазиныг буунд угсарч, гал хамгаалагчийг зохих тавилт дээр тавиад бууг цэнэглэж, буудлагын удирдагчид буудлагад бэлэн болсон тухайгаа илтгэнэ.

- Бууг байнга бай руу чиглүүлэн буудлагын хавтгайд барих, гар бууны хувьд босоо хавтгайд 45 градусаас ихгүй өнцгөөр барихыг зөвшөөрнө.

- Бууг зөвхөн цельд чиглүүлсний дараа гохон дээр хуруу тавихыг зөвшөөрнө. Бусад үед долоовор хурууг гохон дээр тавихыг хориглоно.

- Цэнэглэсэн бууг хараа хяналтгүй орхихыг хатуу хориглоно.

- Гал нээх зөвшөөрлийг зөвхөн буудлагын удирдагч улаан дарцаг өргөөд "ГАЛЛА" командаар өгнө.

- Хоёр гар дээрээс гар буугаар буудах үед гарын эрхий хуруу замгийн ухрах хэсгийн ард байгаа эсэхийг хянах. Энэ шаардлагыг биелүүлээгүйгээс буудах үед замаг ухрахдаа хурц ирмэгээрээ гарыг гэмтээдгийг анхаарах нь зүйтэй.

- Буудлагын үед буунд гацаа гэмтэл тохиолдвол буудагч шууд бие даан гал зогсоож бууг шалган эргэж харалгүйгээр буудлагын удирдагчид мэдэгдэнэ.

- Буудлага хийж байгаа буунд гэмтэл гарсан үед буудлагын удирдагчаас өөр хүн очих буудлагын талбайд нэвтрэхийг хориглоно.

- Буудагч нь магазин дахь бүх сумаа буудаж дууссаны дараа буудлагыг зогсоож буудлагын удирдагчид буудлага явуулж дуусан тухай илтгэнэ. Бүгд буудаж дуусаад илтгэл өгсний дараа "ГАЛ ЗОГСОО" команд өгч цагаан дарцаг өргөнө.

- Буудлагын удирдагч буудлагын төгсгөлд бууг шалгах нэгдсэн команд дохио өгч, үзлэгийг явуулна.

- "ГАЛЛА" командаас өмнө, "ГАЛ ЗОГСОО" командаас хойш буудлага явуулахыг хатуу хориглоно. Энэ командыг зөрчсөн тохиолдолд буудлагыг даруй зогсоож, тухайн тамирчны буудлагын амжилтыг багийн нийлбэр онооноос хасаж дүгнэнэ.

- Галын шугамын ард буу зэвсгийг хуйнаас гаргаж оролдох, аль нэг зүгт хараалах, онилох, чиглүүлэхийг хатуу хориглох ба буу галт зэвсгийг алдагдаж үрэгдэхээс сэргийлж хувийн хатуу хяналтад байлгана.

---oOo---